



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 444

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг
шинэчлэн тогтоож балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 34,900,000.00 (гучин дөрвөн сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины ашиглах хугацааг сунгаж, үнийг 3,500,000.00 (гурван сая таван зуун мянга) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга С.Ням-Эрдэнэ, Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Б.Мөнхтөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005926
23-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 09 дугаар сарын 27 өдрийн
 444 дугаар тогтоолын хавсралт

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
 ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад шилжүүлэх
 автомашины жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил	Шилжүүлэн хүлээн авах байгууллага
1	Хьюндай Соната-7, улсын дугаар 09-59 УНУ, арлын дугаар КМНЕВ41ВАСА438966	2012/2012	1	34,900,000.00	3,500,000.00	3	Сэлэнгэ аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар
	Нийт дүн			34,900,000.00 (гучин дөрвөн сая есөн зуун мянга)	3,500,000.00 (гурван сая таван зуу)		